Төрийн албаны зөвлөлийн 2019 оны
03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ийн БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР, ЧАНАРЫН МЕНЕЖЕРИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтын боловсруулсан үндэслэл:

☐ Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэгдсэн.

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	"Аймаг, хотын ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц орон тооны хязгаарыг батлах тухай" ЦУОШГ-ын А/162 дугаар тушаал
Дагаж мөрдөх огноо:	2025.09.01
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	2025.08.13

Байгууллагын нэр:
Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:
Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженер, чанарын менежер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Төрийн үйлчилгээний мэргэжил ангилал, ТҮМ-6

Ажлын цаг:
Өдрийн 7 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:
Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р баг Тэмүүжингийн гудамж Н-13

Хөдөлмөрийн нөхцөл:
Химийн хортой, хэвийн бус нөхцөл

Онцгой нөхцөл:
Онцгой нөхцөл: Шаардлагатай үед байгаль, орчны ноцтой бохирдол үүсэж, тархсан үед илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

- Орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний хөтөлбөрт ажлыг зохион байгуулах, хэмжлийн нэгдмэл байдлыг ханган, орчны шинжилгээний стандарт, технологийг мөрдүүлэх, бохирдлын эх үүсвэр, орчны төлөв, тойм, зөвлөмж, мэдээ мэдээллээр төр, албан байгууллага, иргэдэд үйлчлэх.
- Итгэмжлэгдсэн сорилтын лабораторийн чадавхид тавих стандарт болон менежментийн тогтолцооны шаардлага, мөрдөлтийг хангуулан ажиллах.

Албан тушаалын зорилт:

1. Монгол улсын хууль тогтоомж, Монгол улсын урт, богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын төлөвлөлт, Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай төрийн бодлого, төлөвлөлт, Засгийн газар, аймаг, орон нутгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах
2. Байгаль орчны шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, удирдах
3. Итгэмжлэгдсэн лабораторийн чадавхид тавих MNS ISO/IEC17025:2018 стандартын техникийн шаардлагыг хангаж ур чадварын сорилт, гадаад , дотоод чанарын хяналт, лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээний ажлыг хийж, шинжээч нарын мэргэшлийн ур чадварыг сайжруулах
4. Орчны чанарын хяналт шинжилгээний ажлын хэмжих хэрэгсэл багаж,тоног төхөөрөмжийн хэвийн тасралтгүй ажиллагаа, бэлэн байдлыг хангах, баталгаажуулалт, шалгалт, засвар үйлчилгээнд хамруулах
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд биечлэн оролцох, лабораторийн аюулгүй ажиллагааг хангуулах.
6. Орчны чанарын хяналт шинжилгээний чиглэлээр, нэмэлт судалгаа шинжилгээ хийх, бодит мэдээллээр төр, засаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлчлэх
7. Шинжилгээний ажлын материал, баримт бичиг, албан хэрэг хөтлөлтийг зохих стандарт журмын дагуу бүртгэж, үдэж архивлах, хадгалах, цаасан болон цахим нэгж үүсгэх.
8. Байгууллагын болон хэлтсийн үйл ажиллагааны тасралтгүй байдал, үүрэг даалгаврын биелэлт, төрийн албан хааагчийн ёсзүйн хэм хэмжээг хангаж ажиллах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	**Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах - **Т**, Хариуцан гүйцэтгэх - **Г** Хянах – **Х** Шийдвэрлэх – **Ш**
1 дүгээр зорилтын хүрээнд	Монгол Улсын хууль, Засгийн газар, БОАЖЯ, ЦУОШГ-аас орчны шинжилгээний мэдээлэл, үйлчилгээний ажлын талаар гарсан тогтоол, тушаал, хөтөлбөр, удирдамж, журам, дүрэм, бусад байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг судлан хэрэгжилтийг зохион байгуулна.	Хэрэгжилт, хувиар	Г,Х,Т,

	Засаг даргын мөрийн хөтөлбөр болон аймгийн дунд ба урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан ажил үүргийн биелэлтийг хангах	Хэрэгжилт, хувиар	Г,Х,Т,
	Салбарын үйл ажиллагаатай холбоотой хугацаатай бичгийн хариу өгөх, гэрээ дүгнэх, тайлан мэдээг заасан хугацаанд явуулах, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Хэрэгжилт, хувиар	Г,Х,Т,
	"Байгууллагын архивын журам", " Албан хэрэг хөтлөлтийн журам" –ын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжилт хувиар	Г
2 дугаар зорилтын хүрээнд	ЦУОШГ-ын даргын 2016 оны А/02 тоот тушаалаар батласан орчны шинжилгээний ажлын хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах	БОШЛ-ын ажлын дүн сар бүр, хувиар	Г,Х,Т,Ш
	Шинжилгээ, судалгааны үр дүнгийн боловсруулалт, ажлын тайлан, үр дүнд хяналт, шалгалт хийх	Тайлан мэдээний чанар, үнэлгээгээр	Г,Х,Т,Ш
	Өдөр тутмын шинжилгээний чанар, химийн шинжилгээний калибровкийг заагдсан хугацаанд тогтмол байгуулах	Шинжилгээний ажлын чанар дүн, хувиар	Г,Х,Т,Ш
	Сорьц дээжний чанарт тогтмол хяналт тавих	Зөрчлийн болон үл тохирлын тоо	Г,Х,Т,Ш
	Бодис урвалжийн хадгалалт, зарцуулалт, хангалт, тээвэрлэлтийн шаардлагыг хангах, хяналт тавих	Зөрчлийн тоо	Г,Х,Т,Ш
	Байгаль орчны хяналт шинжилгээний жил бүрийн дүнг хянаж олон жилийн цуваа үүсгэх, үр дүнд хяналт тавих, үр дүн мэдээг боловсруулж дүгнэлт хийх	Шинжлгээний ажлын дүнг сайжруулсан байдал, үнэлгээ	Г,Х,Т,Ш
	Агаар бохирдуулах томоохон суурин эх үүсвэрийн тооллого хийх ажлыг зохион байгуулах, мэргэжил аргазүйн удирдлагаар хангах, тайлан мэдээг шалгах, нэгтгэх, хүргүүлэх	Тоологын дүн хувиар	Г,Х,Т,Ш
3 дугаар зорилтын хүрээнд	Орчны шинжилгээний лабораторийн чанарын гарын авлагын өдөр тутмын мөрдөлт, MNSISO/IEC17025:2018 стандартын техникийн шаардлага, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, итгэмжлэлийн хугацааг сунгуулж ажиллах	Итгэмжлэлд хамрагдсан байх	Г,Х,Т,Ш
	БОШЛ-ын үйл ажиллагаанд ашиглах MNS ба MNS ISO-ийн 25	Үл тохирол, зөрчил дутагдлын тоо	Г,Х,Т,Ш

	стандартуудыг шинжилгээний ажилд ашиглаж, зааврын дагуу хийгдэж байгаад хяналт тавих, шалгах, дотоод аудит хийж, үнэлэлт өгч, ажиллах		
	Шинжилгээний ажлын болон сорилтын лабораторид мөрдөх журмын хэрэгжилтийг ханган, бүртгэлүүдийг хөтлөн, хяналт тавина.	Хэрэгжилт хувиар	Г,Х,Т,Ш
	Шинжээч нарыг гадаад, дотоод чанарын хяналт шинжилгээ, ур чадварын сорилтонд хамруулах	Сорилын дүн, үнэлгээ	Г,Х,Т,Ш
	Шинжээч нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах мэргэжлийн хичээл заах хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх	Сургалтын тоо, үр дүн үнэлгээгээр	Г,Х,Т,Ш
	Шинжилгээний шинэ арга, аргачлалыг судалж, нэвтрүүлэх, ажилчдыг сургах, эзэмшүүлэх	Нэвтрүүлсэн арга туршлагын тоо, үр дүн үнэлгээгээр	Г,Х,Т,Ш
	Байгаль орчны чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн судалгаа шинжилгээнд оролцох, сургалтанд хамрагдаж ажилдаа хэрэгжүүлэх	Оролцсон сургалтын тоо, хэрэгжилтийн хувь	Г,Х,Т,Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	Хэмжих хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээг төлөвлөгөөний дагуу тогтмол хийх	Төлөвлөгөөний биелэлт, хувиар	Г,Х,Т,Ш
	Багаж төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд хяналт тавих, тохиргоо үйлчилгээ хийх, техникийн паспорт хөтлөх	Гүйцэтгэл хувиар	Г,Х,Т,Ш
	Олон улсын хэмжээнд орчны хяналт шинжилгээний ажилд ашиглаж буй хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийн талаар судалгаа хийх, тохирсон багаж төхөөрөмжийг сонгож захиалах талаар санал гаргах	Багаж, хэмжих хэрэгслийн тоо, чанар, үзүүлэлт сайжруулсан байдал, үнэлгээгээр	Г,Х,Ш
	Хэмжих хэрэгсэл,хэмжлийн багаж, төхөөрөмжийг төлөвлөгөөний дагуу шалгалт, баталгаажуулалт, засвар үйлчилгээнд хамруулах	Төлөвлөгөөний биелэлт хувиар	Г,Х,Т,Ш
	Шинэ багаж төхөөрөмжийг эзэмших, заавар гарын авлагыг мөрдүүлэх, тохиргоо үйлчилгээ хийх	Бүрэн ашигласан байх	Г,Х,Т,Ш

5 дугаар зорилтын хүрээнд	ХАБЭА-н дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах	Хэрэгжилт хувиар	Г,Х,Т,Ш
	Шинжилгээний өдөр тутмын ажилд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрдүүлэн, осол аюулгүй явуулахад хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, зөвлөмж тогтмол өгөх	Хэрэгжилт, хувиар	Г,Х,Т,Ш
	Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахиулан ажиллаж холбогдох мэргэжлийн байгууллагад тайлан өгөх	Хэрэгжилт, хувиар	Г,Х,Ш
	Ажилтны ажлын байрны болон хөдөлмөрийн нөхцөл, онцлогт тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулан, хамгаалах хэрэгслийг олгох санал өгөх, ашиглаж байгаа багаж, хамгаалах хэрэгсэл, бүтээгдэхүүний хэрэглээнд хяналт тавих	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	Г,Х,
6 дугаар зорилтын хүрээнд	Хөтөлбөрт шинжилгээний ажлын үр дүнг мэдээллийн санд байршуулах, хянах, зөрчлийг арилгах	Гүйцэтгэл, хувиар	Г,Х, Ш
	Орчны төлөв байдлын сар, жилийн тойм мэдээ, мэдээллүүдийг гаргах, хянах, цахим сайтуудаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэх ажлыг удирдан зохион байгуулах	Хүргэсэн мэдээний тоо, хэрэглэгчийн тоо	Г,Х,Ш
	Байгаль орчны хяналт шинжилгээний мэдээ, мэдээлэл, тойм, тайлангаар дээд шатны болон төр, засаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, хэрэглэгчдэд үйлчлэх	Гүйцэтгэл, тоогоор	Г,Х,Т,Ш
	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд захиалагч байгуулагуудын хүсэлтээр нэмэлт шинжилгээний ажил гүйцэтгэх	Хийсэн шинжилгээ, хэмжилтийн тоо	Г,Х,Т,Ш
	Орчны шинжилгээний чиглэлээр судалгааны ажил хийж үр дүнг нэгтгэх тайлан гаргах	Гүйцэтгэл үнэлгээ	Г,Х,Т,Ш

7 дугаар зорилтын хүрээнд	Батлагдсан хөтлөх нэрийн жагсаалтын дагуу шинжилгээний ажлын баримтыг архивын заавар, журамд нийцүүлэн зохих бүрдлийн дагуу хадгаламжийн нэгж (ХН) бүрдүүлж архивт хүлээлгэн өгөх	Шинжилгээний ажлын материалыг архивт стандартын дагуу хадгалагдсан байна.	Г,Х,Т,Ш
	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг болон арга зүйн баримт бичиг, зөвлөмж, гарын авлагыг судлан үйл ажиллагаандаа ашиглах	Албан хэрэг хөтлөлтийн чанар сайжирсан байна.	Г,Х,Т,Ш
	Орчны шинжилгээний үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хөтөлбөрийн баримт бичгүүдийг дүгнэх акт үйлдэж, архивлах	Гүйцэтгэл, тоогоор	Г,Х,Т,Ш
8 дугаар зорилтын хүрээнд	Хэлтсийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан ажиллаж биелэлтийг хангах, тайлагнах	Биелэлт хувиар, үнэлгээгээр	Г,Х,Т,Ш
	БОШЛ-ын шинжээч нартай үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан ажиллаж биелэлтийг дүгнэх	Улирал тутам дүгнэсэн байх	Г,Х,Т,Ш
	Харъяалах дээд байгууллага, удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах	Биелэлт үнэлгээгээр	Г,Х,Т,Ш
	Удирдлагын манлайлалыг хангах, мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж, шинээр нэвтэрч байгаа технологи, программ хангамжинд суралцах	Мэргэшил болон хувь хүний хөгжил сайжруулсан байх	Г, Ш
	Байгууллагын шаардлагатай ажлын хэсэг, зохион байгуулалттай үйл ажиллагааануудад оролцох, удирдах	Гүйцэтгэл, үнэлгээгээр	Г,
	Аймгийн байгалийн болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх албаны цацраг, химийн хяналтын багыг удирдан ажиллах	Гүйцэтгэл, үнэлгээгээр	Г
	Төрийн албан хаагчийн ёсзүй, үйлчилгээний стандартыг баримтлан, үлгэрлэн, манлайлж, мөрдөлтөнд өдөр тутам хяналт тавьж ажиллах	Зөрчлийн тоо	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд, Бакалавр зэрэгтэй байх
Мэргэжил	Хими-технологи - D0631 Ус судлал-Усны хими D0668 Байгалийн нэгдлийн хими - D0625 Хүрээлэн буй орчны хими - D0634

Мэргэшил		Мэргэжлийн зэрэг, Байгаль орчны хяналт шинжилгээний чиглэлээр мэргэжлийн курс, сургалт, MNS ISO/IEC17025:2018 стандартын сургалтанд хамрагдсан байх
Туршлага		Байгаль орчны ажиглалт, химийн шинжилгээ хийх, мэдээлэл солилцох. Тайлан мэдээ, мэдээлэл боловсруулах БОШЛ-т 2-оос доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлага эзэмшсэн байх.
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	• Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг үнэлэх • Байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
	Дүн шинжилгээ хийх	• Судалгааны дүнд тулгуурлан салбарын хөгжлийн зорилтыг тодорхойлох • Тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх
	Асуудал шийдвэрлэх	• Хуульд нийцсэн шийдвэр гаргах • Шийдвэрийн төслийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж шийдвэрийн хувилбарын талаар зөвлөх
	Манлайлах	• Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах • Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх
	Багаар ажиллах	• Албан хаагчдын санал бодлыг сонсож, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих • Албан хаагч бүртэй тэгш хүртээмжтэй харилцах, ажиллах
	Бусад	• Албан хэрэг хөтлөх, боловсруулах чадвартай байх • Компьютерийн өргөн хэрэглээний болон салбарын үйл ажиллагаанд ашиглагддаг программ, технологиудыг ашигладаг байх • Англи хэл эсвэл бусад гадаад хэлнээс мэргэжлийн дагуух эх сурвалж, мэдээллийг ашигладаг байх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: 1. Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: 1. Байгаль орчны шинжилгээний ахлах шинжээч -1 2. Байгаль орчны лабораторийн шинжээч -1 Нийт: 2	Бусад харилцах субъект: 1. Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторийн инженерүүд 2. Цаг уур орчны шинжилгээний газрын мэргэжилтнүүд 3. Ус цаг уур орчны шинжилгээний төвийн инженер, техникчид 4. Аймаг, сумын засаг даргын тамгийн газар 5. Орон нутгийн мэргэжлийн болон аж ахуйн нэгж байгууллагууд 6. Төсөл, хөтөлбөрийн мэргэжилтнүүд 7. Хэвлэл,мэдээллийн байгууллагууд 8. Онцгой тохиолдолд бусад субьект

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	**Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:**
Албан тушаал: Хүний нөөцийн ахлах ..... С. Баясгалан (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 8 дугаар сарын 13-ны өдөр	Байгууллагын нэр: Ус цаг уур орчны шинжилгээний төв Шийдвэрийн огноо: 2025.08.13 Дугаар: Ф/44

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: Үндэсний	
Шийдвэрийн огноо: 2025.08.13	
Дугаар: Ф/44	
(тамга/тэмдэг) ..... (Б.Хэрлэнчимэг) (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2025 оны 8 дугаар сарын 13 өдөр	

ТАНИЛЦСАН.....